

**ХХ зуунд Монголд гарсан хөрөнгөлөг
ардчилсан хувьсгалын асуудалд**

Доктор /РН/, профессор С.Отгонжаргал /МУИС/

ХХ зуунд Монгол орныг донсолгосон улс төрийн гурван томоохон үйл явц болсны хоёр дахь нь буюу 1921 онд болсон хувьсгалт үйл явц нь Монгол улсын түүхийн хуудаснаа голлох байр суурийг эзэлдэг хийгээд уг хувьсгалын асуудлаар одоог хүртэл түүхчид, судлаачдын дотор санал бүрэн нэгдмэл болж чадаагүй байгаа юм.

Энэхүү хувьсгалын асуудал нь ХХ зууны Монголын түүхийн цөм асуудал, зангилаа асуудал болохынхоо хувьд судалгааны явцад чухам ямар дүгнэлт шийдэл гарснаас ХХ зууны 20-иод оноос хойши Монголын түүхийн хөрс суурь тодорхойлогдох юм. Иймээс 1921 оны хувьсгалыг шинж маяг Монгол улсын түүхэнд эзлэх байр суурийн хувьд нь, түүний үр дагавартай нь нягт холбоотойгоор нарийвчлан судалж нэлээд боловсронгуй үнэлэлт дүгнэлт өгөх явдал нэн чухал ач холбогдолтой байгаа юм.

1921 оны Монголын хувьсгалын асуудлыг манай болон гадны зарим эрдэмтэд судлах явцдаа харилцан адилгүй санал дүгнэлтийг дэвшүүлсэн байдаг. Өрнөдийн болон манай зарим заруулж судлаачид 1921 оны Монголын хувьсгал бол Орос улсаас Монголд хүчээр экспортолж авчирсан, нийтэй эдийн засгийн урьдчилсан нөхцөл тохиоргуйгээр шууд хийгдсэн хувьсгал гэхийн зэрэгцээ өрөөс 1921 оны үйл явц нь хувьсгал мөн үү биш үү гэсэн санааг дэвшүүлсэн байдаг юм. Дэлхийн Монгол судлалын шанг анхлан татагчдын нэг профессор О.Латтимор монгол орноор аялан эрдэм судлаалаа бодит амьдралд тулгуурлан явуулах явцдаа 1921 оны хувьсгалын асуудлыг онцгойлон судалж, “Нүүдэлчид ба хувьсгалчид” номондоо уг хувьсгалын талаар “Монгол хувьсгал анхнаасаа коммунист зохион байгуулалтын зарчмаар явагдсаныг жирийн партизануудын дуртгал харуулж байна. Түүний /хувьсгалын С.О./ цөмийг “мэргэжлийн” хувьсгалчид /коммунистууд С.О./ бүрдүүлж байсан бөгөөд тэд зөв улс төрийн байр суурь угий бол зоригтой эх оронч цэргүүдийг хүртэл намд элсүүлэн авдаггүй байжээ” гэсэн байдаг.

Латтимор абугайн энэхүү бичсэнээс үзэхүүл уг хувьсгалыг удирдан жолоодсон МАН-ын бүхий л асуудал коммунистуудын гарч байсан хийгээд эхнээсээ коммунистуудын хувьсгал буюу Оросоос Монголд экспортолосон хувьсгал юм гэж өрнөдийн судлаачдын дүгнэх бичдэгтэй нэгэн утгатай санааг илэрхийлсэн байдаг юм. Энэхүү саналыг зарим монгол эрдэмтэн судлаачид ч мөн түүх сонирхогчид ч өөрсдийнхөө зохиол бүтээлд тусгаж ирснийг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Гэхдээ дээрх саналаас гадна 1921 оны Монголын хувьсгалын асуудлыг боловсруулахад манай ахмад түүхчид эрдэмтэд жинтэй бөгөөд асар их хувь нэмэрээ оруулсан юм. Энд бил академич Б.Ширэндэв, академич Б.Лхамсүрэн, академич Б.Норовсамбуу, доктор М. Санждорж, проф. Л.Бат-Очир, проф. Ц.Сүрэнхорлоо, доктор Ж.Болдбаатар, дэд доктор Д.Даш нарын зэрэг олон эрдэмтдийг хэлж болно. Эдгээр эрдэмтэд Монголын хувьсгалын үүсэл хөгжил хувьсгалын тохироо бүрэлдсэн, МАН-ын шинж чанар, хувьсгалын ялалт шинж маяг ач холбогдлын асуудлыг өөрсдийнхөө бүтээлүүдэд хэндэж тавьсан хийгээд дээр дурдсан хувьсгалын асуудлуудад шинжлэх ухааныг үндэстэй хариу өгөхийг оролдсон мөн хувьсгалын эхэн үеийн ээдрээтэй асуудлыг судлах замаар 1921 оны хувьсгалд зохих үнэлэлт дүгнэлт өгөхийг чармайсан шинжлэх ухааны

үндэстэй саналуудыг дэвшүүлсэн байдаг юм. Үзэл суртлын хатуу дэглэмийн үед "Чингис" гэдэг нэрийг бичих нь бүү хэл, хэлэхийг хориглож байсан хүнд үед дорнын их яруу найрагч Б.Явуухулан "Би хаан төрөө вэ?" алдарт шүлгэндээ "Миний өвөг дээдсийн морин турайндаа наалдсан, хүний нутгийн шороо"² гэж Чингисийн байлдан дагууллыг битүү боловч маш тод томруун гүн ухагдахуунаар сэтгэлд хоногштол яруу дүрсэлсэн байдаг. Үүн лугаа адил 1921 оны хувьсгалын асуудлыг манай түүхчид боловсруулах явцдаа уг хувьсгалын асуудлыг цаашид үргэлжлүүлэн судлах шаардлагатай байгааг сонирхолтой гаргалгаанудаар битүүхэн илэрхийлсэн байхын зэрэгцээ хувьсгалын үйл явцыг он цагийн дарааллыг баримтлан цэгцтэй гаргаж тавьсан нь өдгөө бидэнд уг асуудлыг дахин нягтлан судлахад дэвсгэр болж байгаагаараа давхар ач холбогдолтой байгаа юм. Эдгээр эрдэмтдийн бүтээлээс гадна эдийн засгийн ухааны дэд доктор Ш.Бат-Очир "БНМАУ-ын шилжилтийн харьцааны үеийн зарим асуудал" бүтээлдээ онцгой сонирхолтой санал дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, 1921 оны хувьсгалыг "Монголд 1921 онд үүссэн хувьсгал, хөрөнгөтний ардчилсан хувьсгал боловч урьд хаана ч байгаагүй шинэ маягийн ардчилсан хувьсгал байжээ"³ хэмээгээд "Энэ хувьсгалыг хийхэд дотоодын гол оролцсон хүч нь жижиг хувийн өмчтөн байсан учраас хөрөнгөтний ардчилсан хувьсгал гэж нэрлэж болно"⁴ ардын энэ хувьсгалт хөдөлгөен эхлээд хөрөнгөтний нөлөөний дор орсон бол харин манай аажимдаа хөрөнгөтний нийгмийг тогтоо чиглэлд хөгжих нь гарцаагүй байв"⁵ гэж тодорхойлсон байна. Энэ мэтээр дээрх судлаачдын дэвшүүлсэн саналуудыг 1921 оны хувьсгалын түүхэн үйл явцын талаархи архивт хадалгадан үлдсэн баримт материалын зэрэгцүүлсэн авч нарийвчлан судлах зорилтыг тавихдаа 1921 оны хувьсгалын шинж маягийн асуудлаар өөрийн санал дүгнэлтийг гаргаж тавих нь зүйтэй хэмээн үзсэн юм. Гэхдээ энэхүү санал нь манай эрдэмтдийн оруулсан түүхэн хувь нэмэр дээр тулгуурлаж, түүний улам бататгахыг эрмэлзэхдээ ер нь цаашдаа Монгол улсын түүхийг ялангуяа 1921 оны хувьсгалын түүхийг судлах, суралцах ухаарах явдалд далайд дусал нэмэр хэмээн үзэж байгаа юм.

Ерөөс 1921 оны хувьсгал гарах үеийн Монгол орны нийгэм-эдийн засгийн төрх байдлыг ерөнхийлөн тодорхойлвол юуны түрүүнд үеэс өнгөрөөсөн феодалын харилцаа, өсөн дэвжих тасралтуйг хөгжих байх зүй тогтол бүхий үйлдвэрлэн бүтээгчдийн хоорондох зөрчил дээд шатандаа хүрч үндэсний ардчилсан хувьсгал гарах хөрс суурь нэгээнт бий болсон байв. Ийм ч учраас 1921 оны хувьсгал үүсэн мандахаасаа эхлээд үндэсний тусгаар тогтнол, нийгмийн ардчилсан байгууллыг тогтоохын төлөө тэмцлийн шинж төрхийг агуулж байв. Энэхүү шинж төрхтэй нягт уялдаатайгаар монгол хүн Монгол эх орноо өөрсдөө запуурдан авч явах ёстойг батлан, улс төрийн хоосон орон зайг дүүргэн, түүхийн тавцнаа анх удаа улс төрийн бат бэх хүчин болж гарч ирсэн МАН нь үндэсний ардчилсан шинж төрхийг өөртөө агуулж байлаа.

1919 оны Монгол оронд Сүй Шу Жаны цэргийн түрэмгийллээр Монголын автономитыг устгаж хятадын харьялалд багтаах ёслолын ажиллагаа болсон байдаг. Энэ тухай "モンгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх" номонд "Богдыг Да Зунтунгийн /Их Ерөнхийлөгч С.О.-ийн зурагт гурав дахин мэхэсхийлгэж тамга өргөмжлөлтийг гардан хүлээлгэж өгмөгц, ... Богд болон ард олныг хятад гартаа атгаж авсан шинж мэдэгдэв хэмээн олноор түрхэрэн шуугилдаж, энэ өдөр толгойг дээш хандах хүн нэг ч угүй, цөм уруу хандан гутамшиг зовлонг хүлээн, ... эхнэр хүүхэд, етгэс чавганц хүртэл үйлж залбирах ба зарим нь нүднээс бөөн бөөн нулимын унагаан, хангинал шүүрс алдаж байхыг үзэв"⁶ гэсэн байдаг. Буурай Монгол орны тусгаар тогтнолд учирсан энэхүү гамшигийг Монголчууд сэтгэл зүйн гүн хямрааар хүлээж аваад хүлцэж суусангүй

харин ч улс төрийн томоохон хүч болон зохион байгуулагдах шинэ эрч хүчийг эндээс л олж авсан байна. Энэ өдөр дээдэс доодосгүй улс орноо хэрхэн аврах тухай шаналж байхад Монголын сэхээрэлт хүмүүс үүнээс гарах гагц зөв зам бол гаднаас тусlamж авах явдал гэж үзсэн байдаг. Энэ л өдөр Данзан, Догсом, Дэндэв гурав уулзаж, улс төрийн хэргийг бие биенээсээ үл цэврэн хэлэлцэж их эрэл хайгуулын эцэст удалгүй Зүүн Хүрээнд улс төрийн шинж бүхий нууц бүлгэм байгуулагдаж баход консулын дэнжид Бодоогийн санаачлагаар 2 дахь бүлгэм байгуулагдсан байна.

Энэ үед монгол орон дээр дооргүй хөдөлж Монгол орноо хэрхэх тухай ирээдүйд зовнин байхдаа Америк улсаас тусlamж гүйх тухай санал гарч гашуудал бичгийг үйлдэж тэр үеийн хүрээнд байсан америкийн нөлөө бүхий худалдаачин Лан-Си-сан-иар уламжлуулан тусlamжийг хүссэний зэрэгцээ Япон улсаас тусlamж гүйх бичгийг давхар үйлдэж, Богдын тамга даруулж, гүн Рагчаагаар уламжилсан байдаг. Үүнээс үзэхүл монголын дэвшилтэт хүчин чухам хэнээс тусlamж авах нь гол биш монгол орныхоо тусгаар тогтолыг хамгаалж үлдэх нь тэдний гол үндсэн зорилго болоод байсныг тодорхой мэдэж болох юм.

Түүхэн энэ эзэгэлтийг үед хувьсгал ялсан Орос орны Засгийн газраас Монголын ард түмэнд хандаж тусгай уриалга гаргаж түүндээ "Монгол улс тусгаар тогтносон орны ёсоор Бээжин Петроград хоёроос асуулгүй аливаа олон улс лугаа шууд харилцан нэвтрэлцэх эрхтэй"⁷ хэмээн тунхагласан нь Монголын сэхээрэлт хүчин анхаарлыг зүй ёсоор татсан байна. Эдгээр сэхээрэлт хүч энэхүү оронд хандахдаа социализмын мөн чанар, тухайн оронд болсон хувьсгалын утга учрыг ухааран тунгаах, хүлээж авах зорилт тавиагүй хийгээд гагц цэрэг зэвсгийн тусlamж авч улс орноо харийн түрээгийлэгчдээс цэвэрлэж авахыг эрхэм болгож байлаа. МАН-ын үр хөврөл болох анхны нууц бүлгэмүүдээс олон түмэнд хандаж гаргаж байсан уриа, тунхаг наалдуулсан бичигт энэ байдал тодорхой туссан байдаг. Тухайлбал, эдгээр түүхэн баримт бичгүүдэд "шашин үндсэнд харшлах харгис дайсныг цэвэрлэж, алдагдсан эрхийг эгүүлэн аваад, төр шашныг үнэн сэтгэлээр бататган мандуулна"⁸ гэсэн санаа гүн бат шингэсэн байдгийн зэрэгцээ ирээдүйд тогтоно засаг төрийг ч тов тодорхой заахдаа "Гадаад Монголын улс төрийн дээд зэргийн эрх барих газар нь Монгол Улсын төлөөлөгчдийн их Зөвлөл хэмээх хуралдаан болно... Улсын их зөвлөл нь Сайд нарын Зөвлөлийн хүмүүсийг сонгохоос гадна улсын тэргүүлэгчийг сонгож суулгана. Улсын сонгомол тэргүүлэгчийн орыг түүний хөвгүүд буюу шадар төрсөн нь залгамжлан суух бус, Чингис хааны үед сонгуулиар суулгадагчлан бүгд Монгол улсын төлөөлөгчдийн их Зөвлөлөөр сонгогдож суулгагдах амой."⁹ гэжээ. Монголын хувьсгалчид, МАН үүссэн цагаасаа л Монгол орныхоо тусгаар тогтнол ирээдүйн хөгжлийн төлөө ухаан уралдуулах, улс төрийн эрүүл орчин бий болгох "угсаа залгамжлах, эрдэм ухаангүй засгийг халж" парламентад засаглал тогтоох зорилтыг өмнөө тавьж байв.

1920 оны VI сарын 25-н болоод ирэхэд 2 нууц бүлгэмийн үйл ажиллагаа улам өргөжиж, өөрийн гэсэн өнгө аяасаа олж олон арван гишүүдтэй болж бэхжсэний зэрэгцээ хоёул бие биенээ мэдсэнээр нууц бүлгэмийг үндэслэн байгуулагч С.Данзангийн гэрт анх удаа хамтарсан хурлаа хийж, МАН гэсэн хувьсгалт байгууллагыг байгуулж, МАН-ын хүмүүсийн тангаргийн бичгийг баталж, намын тамгыг баталсны үндсэн дээр ЗОУ-аас тусlamж гүйхаар намын биет төлөөлөгчийг томилон явуулах шийдвэр гаргаж хожмоо хувьсгалын 7 гэж алдаршсан, намын үйл хэргийг гардан гүйцэтгэж байсан хүмүүсээ нэр заан томилсон байна. Энэхүү төлөөлөгчид маань хувьсгалт байгууллагынхаа даалгаврыг амжилттай биелүүлж, ЗОУ-ын Засгийн газрын эрх мэдэл бүхий төлөөлөгчидтэй уулзаж, дараах хариуг авсан байна. Энэ тухай үндэсний

хувьсгалын товч түүх номонд дурсан бичсэнээр "Данзан Чагдаржав нараас хэлсэн нь: Бид нар Москва дахь Коминтерний дорнод болон тэдний намын эрх баригчид нар биднийг нэгэн өдөр аваачиж, танай зорьсон эл хэрэгт тусlamжийг бүрэн дүүрэн хангалттайгаар өгнө, буу зэвсэг, мөнгө туслах явдлыг энэ удаа тоо тогтоох хэрэггүй, танай юу зорьсныг манай улс заавал гүйцэтгэж өгнө"¹⁰ гэсэн байдал. Ингэж МАН-ын төлөөлөгчид ЗОУ-ын албан ёсны төлөөлөгчидтэй нүүр учран уулзаж их гурэн, бага буурах хоёр орны хооронд түүхэнд анх удаа аман хэвлэлцээрийг байгуулсан хийгээд энэхүү хэвлэлцээрийг дипломат уг зүйд жентельменский договор гэж хэлж хэрэглэсээр иржээ. МАН гэдэг хувьсгалт байгууллагын ар талд монгол эх орон, Богд хаан, хар шар феодал харц ард цөм нэгэн хүч болон зогсож байсныг энд тэмдэглэх нь эй болов уу. Учир нь МАН, Богдын Засгийн газар хоёрын хооронд дайсагналцсан уур амьсгалт байсан тухай биднийг "социализм" байгуулж байх үеийн ном зохиолд олонтоо батлан бичсэн байдгийг та бид андахгүй. Үүнээс эрс ондоо дүгнэлт хийхийн тулд юуны түрүүнд баримтанд тушиглээ. МАН гэдэг хувьсгалт байгууллагын төлөөлөгчид ЗОУ-аас тусlamж гүйхаар явах гэж байгаа тухайгаа Богд хаанд нэг биш удаа мэдэгдэж зөвшөөрөл хүсэж байсан тухай МАН-ыг үүсгэн байгуулагдын нэг, ЗОУ, Коминтернтэй холбоо тогтоохоор нууцаар явсан төлөөлөгчдийн нэг болох, их бичгийн хүн Д.Догсом, "МАН-ын түүхэнд холбогдох бүхий зүйлүүд" 1928 онд хэвлэгдсэн номонд Богд хаанд хэд хэдэн удаа бараалхаж, хойшоогоо тусlamж гүйхаар явах гэж байгаа тухайгаа мэдэгдсэн талаар бичээд, хамгийн сүүлд 1920 оны зуны эхэн сард анх дуаа Богд хаанд бараалхаж зуны өргөөнд С.Данзангийн хамт орсон тухай, мөн гэр доторхийг нүдэнд үзэгдэхээр тодорхой сүслэн биширч бичиж үлдээсэн байдал. Богд хаанд тэдэнд зөвшөөрөл өгөөд зогссонгүй харин ч хүн тус бүрд бурхан бүтээж өгч, зорьсон их хэргээ саадгүй бүтээхийг хүсэмжилсэн зэргээс үзэхүүл харийн түрэмгийлэгчдийн эсрэг Монгол оронд улс төрийн нэгэн фронт байгуулагдсан байжээ гэж үзмээр байгаа юм.

ЗОУ-аас тусlamж авах нөхцөл бололцоо бүрэлдсэн үед буюу 1921 оны III сарын 1-ний өдөр МАН гэдэг хувьсгалт байгууллагын хурал хуралдаж, уг хурлаар МАН гэдэг улс төрийн зохион байгуулалт бүхий нам байгуулагдсан нь Монгол улсын сайн муу бүхий л ачааг үүрэх төөрөг зурагтай байсан аж.

1921 онд байгуулагдсан МАН нь зорилго нэгтэй өөр суртлын нам байж болохыг баримт бичигтээ тусгаж заасан байдал нь бий болмогцо олон намын систем, улс төрийн плюрализмыг хүлээн зөвшөөрч байжээ гэж үзэлтэй байгаа юм. Харин гадны хүчирхийлээр капиталист биш хөгжлийн замыг жанжин шугамаа болгосон МАХН-ын III их хурлаас "МАХН-аас өөр улс төрийн нам гарахгүй байвал зохино" гэж онцлон зааснаар Монгол оронд ганц намын систем тогтох эх үндэс тавигдсан байна. МАН нь ийнхүү байгуулагдмагцаа хувьсгалын үйл хэргийг улам шуурхайлсан зохион байгуулж, Монголын ард иргэд олон түмнийг хувьсгалт тэмцэлд нэгэн фронт болгон босгож чадсан байна. Үнэхээр ч Монгол орны өнцөг булаг бүрээс ангийн буу, хөтөлгөө морьтойгоо ард иргэд, хувьсгалд шулуудсан партизанууд маань МАН-ыг л аврагчaa хэмээн үзэж сураг ажиг тавьснаар түшиг хүчин нь болж чадсан юм. Энэ түшиг хүч болсон ард түмэн бүгд өмчтөнгүүд байсан юм. Монголд урьд өмнө нам байсан түүхэн уламжлал байгаагүй, мөн улс төрийн зохион байгуулалттай байгууллага байх нөхцөл урьд байгаагүй атар онгон газар хөрсөн дээр байгуулагдсан МАН маань хичнээн шинэ залуу, туршлагагүй байсан хэдий ч нөнө нуруу хазайлгүй хувьсгалд тавьсан стратегидаа үнэнч байж, горилж сүсэглэсэн ард түмнийхээ итгэлийг алдалгүйгээр хувьсгалыг ялалтанд хүргэсэн билээ.

МАН-ын хувьсгалд тавьсан стратеги нь үндэсний тусгаар тогтол, нийгмийн ардчилсан байгууллыг тогтооход чиглэгдэж байсан юм. Ерөөс аливаа

хувьсгалын хэв маягийг тухайн хувьсгалын шийдэж байгаа нийгмийн цөм болох асуудлууд, тухайлбал, унаж байгаа төрийн оронд тогтнон мандах төр засгийн бүтэц, улс орноо, хүн ардаа чухам юуны төлөө хааш нь удирдаж байгаа болон, хувьсгалын үр дүнд тогтоносон буюу төлөвшин тогтнож буй нийгмийн байгууллын мөн чанараар тодорхойлогдон баримжаалдаг билээ.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалтын дараа ардын төр засаг, эрх баригч МАН, Монгол оронд хөрөөнгөлөг нийгмийн эдийн засаг, үндэсний соёлыг орчин цагийн шинжлэх ухааны үндэс, соёл боловсролтой холбон хөгжүүлэх замд шилжин орсон. Төр засаг, МАН-аас Монгол орны эдийн засагт олон хэвшил зэрэгцэн оршиж байнсныг хүлээн зөвшөөрч, хувийн жижиг аж ахуйг чөлөөтэй хөгжүүлэх, гадаад дотоодын худалдааг дэмжих, хувийн жижиг, том өмчийг чөлөөтэй хөгжүүлж, улс орныг хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг замаар хөтлөх бодлого баримтлаж байв. Тухайлбал, МАН, Засгийн газраас гадаадын худалдааг хөхүүлэн дэмжсэнээр /худалдааны тэмдэгтийн тоогоор/ худалдаачид бүгд 1922 онд 1131, 1923 онд 1941, 1924 онд 2325 болтлоо өссөн байна. Үүнээс хятад худалдаачид 1922 онд 863, 1923 онд 1571, 1924 онд 1462 болсон байхад, Америк, Германы худалдаачид 1922 онд 5, 1923 онд 26, 1924 онд 62 болтлоо өссөн нь төр засаг, МАН-ын улс орноо хөгжүүлэх хэтийн төлөв, шуудхан хэлэхэд капитализмд урсан ороход чиглэгдэж байсан нь тодорхой байгаа юм. МАН төрийн зүтгэлтнүүдийн бичиж, хэлж үлдээсэн олон баримт бичгүүдэд Монгол орны өвөрмөц нөхцлийг цохон тэмдэглэж, жижиг өмчтөний хөр суурийг эвдэх боломжгүй зааж, аль нэг орны ес заншлыг хуулбарлан дууриах нь многолын ирээдүйн байдал төлөвт муугаар тусахыг сэргэжмэлүүлж байв. Тухайлбал, А.Амар "Монгол угсаатны дээд сайн байдал болбоос, өөрийн заншил байдал хэв сурталдаа цэнгэлдэн аж төрж, бусад ямар ч этгээдийн дарлал хавчилтуй, өөрийн эрх дураар байх ... явдал маш эрхэм болно, алив нэгэн үндэс угсаатны өөр өөрийн сурч дадсан зан сургал нь өөр өөрсдөө эрх, жаргалтай мөн тул бусад этгээдийн ямар сайн сайхан зан заншил байдал хэмээвч тохирч тэнцэх бэрх болно"¹¹ гэсэн байхад, Ц.Дамбадорж, Ж.Цэвээн нар "бусдыг мөлжихгүйгээр аль болох их баяжигтун", "хүний гол гол зорилтыг олны тусад хандуулбал баяжихыг хориглож болохгүй", "ЗСБНХУ, хятад хөөроос баталсан бөгөөд бух гүрнээс зөвшөөрсөн Швейцар мэт төвийг сахисан улс" болох нь хэтийн зорилго байх ёстой хэмээн үзэл бодлоо илэрхийлж байхад С.Данзан МАНЫН III их хурал дээр "ертөнцийн хүн төрөлхтэн нь илэрхий тэнэмэл ба нүүдэл, суурьшсан ба боловсорсон ... мэтийн олон зэрэг дэс байх бөгөөд үлгэрлэвээс авирах гишгүүрт нэгээс үүсгэн дэвших ба усанд гүехнээс гүнд орохоор одохын адил буй. Үүний зэрэг дэс дэс солигдоос үл болох буюу"¹² гэж Монгол орны баримтлан чиг болгох нийгэм нь капиталист нийгэм мөн болохыг шулуухан хэлсэн байдаг.

МАН-ын анхны дарга С.Данзангийн бодит үйл ажиллагаа ч хэлснээсээ огт гажсангүй тэрээр хувийн өмчийг зүйл бүрээр дэмжихийн зэрэгцээ өрөө ч төрж буй хөрөнгөлөг давхаргын биет төлөөлөгч байв. Тухайлбал, С.Данзан нь Хятадын том пүүсүүдийн бараа таваар зөөхөөр, Хүрээ-Жанчхүүгийн замд байгуулсан хятадын хувийн "Фу-Лай-Хо" хэмээх авто тээврийн компанид хувь нийлүүлэхээр элсэж, Англи-Америкийн Бирдман, Роберт Смит, Уильман зэрэг пүүсүүдтэй шууд холбоотой байснаас гадна Хятадын "Тун-Хо-Хо" пүүстэй гэрээ хийж хувийн төмөр зам тавиулах асуудлыг тохирч байжээ. Тэрээр 1923 он гэхэд гурван том байшин бариулж, автомашинуудтай болсноос¹³ үзэхэд шинэ нийгмийн томоохон төлөөлөгчдийн нэг байжээ. МАН-ыг үүсгэн байгуулагч Д.Чагдаржав ч, мөн С.Данзангийн нэгэн адил шинэ тутам төрж байсан жижиг хөрөнгөтний төлөөлөгчдийн нэг байлаа. Хувьсгал ялахаас өмнө тэрээр эцгийгээ даган хувийн

худалдаа эрхэлж байхын зэрэгцээ Англи, Итали, Польш, Орос орноор явж юм үзэж нүд тайлсан" нэгэн байв. Ардын Түр Засгийн Газрын анхны даргаар ажиллаж хувьсгалын дараа Монголын Харилцан Туслалцах хоршооны даргаар ажиллахын зэрэгцээ өөрийн хувийн хоршоог байгуулж, хошуудад салбар хоршоогоо нээн ажиллуулж өмчийн тал дээр нилээд бэхжих байсан байна.

Монгол дахь хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын партизан, МАН-ыг үндэслэн байгуулагчдын нэг Ажваагийн Данзан нь хувьсгалын өмнө "Японд очиж Токиогийн ойролцоо Иокогама хотод суурьшин ангийн арьс үсний пүүсийн эзэн хэмээгдэн алдаршихдаа японы үйлдвэр худалдаа, цэрэг улс төрийн нөлөө бүхий хүмүүстэй танилцаж байр сууриа бэхжүүлсэн"¹⁴ байсан тэрээр хятад, төвд, япон, орос, англи хээлийг сайн эзэмшсэн өндөр боловсролтой нэгэн байв. Хувьсгал ялсны дараа МАН, тэр засагтаа үнэнчээр зүтгэхийн зэрэгцээ хувийн аж ахуйгаа улам хөгжүүлж Японд хувийн банкны салбараа нээсэн тухай дам мэдээ байдаг. Сангиин яамны зөвлөх түшмэл, МАН-ын дарга, дэд дарга, Гадаад явдлын яамны орлогч дарга Москвад суух элчин сайд зэрэг томоохон албыг хашиж байсан Баатад овогт Ажваагийн Данзан Монгол орноо хөрөнгөлөг замаар хөгжүүлэх МАН-засгийн манлай бодлогыг хэрэгжүүлэхдээ тууштай зүтгэж англи, америк япон, герман мэргэжилтийг өргөн ашиглах бодлого явуулж мөн Герман, Япон, Дани улсад монголын заплуучуудыг сургах ажлыг идэвхийлэн хөөцөлдөж байжээ. А.Данзан нь С.Данзан, Д.Чагдаржав нарын нэгэн адил Монгол орныхоо ирээдүй хойч хөгжлийн төлөө амь бие хайрлгүй зүтгэгчийн нэг, МАХН-ын мянган шилдэг гишүүдийн ног байв. Үнэхээр хувьсгалд сэтгэл шулуудан орсон хувьсгалчид маань хотон дахь хонио нийгэмчлье гэсэн уриа поозонг энд тавиагүй юм.

1921 оны хувьсалаар тавигдсан зорилтонд Монгол орныг хөгжлийн тодорхой өндөрлөгт хүргэх гагц зам нь жижиг өмчтөнөө хөхүүлэн дэмжиж, зах зээлийн эдийн засгийг баримжаалах явдал хэмээн үзэж байсан байна. Тухайлбал, 1923 онд боловсрогдсон "Эдийн засгийн үндсэн бодлого" баримт бичгийн 17 дугаар зүйлд "Монгол улсын гадаадын худалдааны учир байцаавал Орос, Хятад, Рибин, Америк, Англи, Герман зэргийн олон их бага улс дотроос ... худалдаа ашиг, эрдэм соёлын тухай гэрээ болзоо тогтоон нэвтрэлцэхэд хүрвэл эрхбиш хэдэн давхар эрэгцүүлэн хянаж тогтоовол зохино. Герман, Англи, Орос, Америк, Хятад, Рибин хэмээн шилж сонгоход хүрвэл аль ч талаар Герман, Орос, Америк хэмээх мэтээр дэс дараалан орно заа"¹⁵ гэжээ. Үүнээс үзвэл нээлттэй зах зээлийн бодлого тодорхой байгаа бөгөөд аль хөгжилтэй, мөн дөт оронтой худалдаа эрхлэх зорилгыг өмнөө тавьсан байна. Мөн уг баримт бичигт боловсролын асуудлыг өндөрт тавьж улс орныг сонгож суралцуулах талаар заахдаа "Урьд эдүгээ аль ч цагт, орон газар хаана ч атугай эрдмээр илүү нь эрхбиш түрүүлдэг учиртайг дэлхий дээрхи олон улс ухамсарлан мэдэж, эрдэмд боловсруулахыг засгийн бодлогын манлай болгожээ ... Герман улсын ард нэгэн түмэн эр, эм дотроос дөрөвхөн нь бичиг үл мэдэх, английн уул улс дотор нэгэн түмэн хүний арваад хүн бичиг үл мэдэх буй, оросын түмэн хүний дотор долоон мянга нь бичиг үл таних мэт үлгэртэй бөгөөд эрдэм соёлоор баялаг нь эд хөрөнгө, чадал хүчээр аянаа баялаг ажгуу"¹⁶ хэмээн үзэж эрдмүүдэд сургахыг урьдал болгох, олон үйлдвэрийн дунд ба дээд эрдмийг гадагш явуулж сургах зэрэг зорилт дэвшигдсэн байна. Энэ дагуу монголын заплуучуудыг сургахаар явуулахдаа тавыг нь Парисийн эдийн засгийн сургуульд, хорийг нь Германы янз бүрийн сургуульд суралцуулахаар илгээсэн байдаг. Гэтэл энэ нь гар сунган тусласан ЗХУ-д таалагдсангүй нь дараах архивын баримт бичгээр илрэхийлэгдэж байгаа юм. ЗСБНХУ-ын Гадаад хэргийн ардын комиссариатын газар нөхөр Каракан танаа гэсэн бичигт "бидэнд байгаа мэдээгээр МАХН-ын эрх

барж байсан баруунтан удирдагчид хөрөнгөтөн орнуудын сургуульд 25 сургач илгээжээ. Монголын засгийн газарт зохих хэлбэрээр дараалт үзүүлж Франц, Германц суралцаж буй монголчуудыг татуулан улмаар заплуучуудыг тэдгээр оронд сургуульд цаашид илгээхээс татгалзуулах нь чухал¹⁷ гэж ажилчин тариачны улаан армийн жанжин штабын IV газрын дарга Берзин мэдэгджээ. Энэхүү шахалт дарамтын улмаас Монгол улс 25 оюутнаа эгүүлэн татсан юм. Эдгээр 25 оюутнаас манай шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдорж, төрийн соёрхолт зохиолч Д.Намдаг, ардын багш Г.Батсүх, төрийн шагналт зураач Л.Намхайцэрэн, гавьяат багш Бавуу, доктор Ж.Дүгэргүрэн, гавьяат зоотехникич Т.Аюурздан зэрэг манай сэхээтнуудийн сор болсон хүмүүс төрж гарсан нь хөгжилтэй оронд шилж сонгож сургалав буурай Монгол орон хойч ирээдүйд “элдэв зүйлийн боловсон арга хэрэглэж, эд хөрөнгө зузаан, сүр хүчин их болно” гэсэн МАХН-ын бодлого зөв зүйтэй байсныг амьдралын энэхүү бодит жишээ тодорхой харуулж байгаа юм. Үнэхээр ч гадны нөлөө оролгүйгээр намын энэхүү бодлого хэрэгжсэн бол Монгол орны өнөөгийн дүр төрх эрс өмнөө байх байсан буй за.

Гадны түрэмгийлэгчдийн хөлд тусгаар тогтнолоо алдах аюул нүүрлээд байсан түүхэн эгзэтгэй ХХ зууны 20-иод оны үед Их гүрнээс цэрэг зэвсгийн бодит тусламж авах таатай нөхцөл бүрэлдэж сээтэл харамгүй тусламж авсан нь Монгол орны хувьд өнөөдрийг хүртэл тусгаар орших, эрхшээлт замын дор сэргэн мандах эхлэл тавигдсан. Гэхдээ гар сунган тусалсан пролетариин орон, жижиг өмчтэн давамгайлан Монгол орон хөёрын хооронд дэндүү хол ялгаа байсан нь хожмоо хурц илэрч их гүрний эрхшээлд орсон нь түүхэн үнэн билээ. Тусламж авч нийгмийн хувьсгал хийсэн Монгол орон өөрийн өвөрмөц нөхцлөө дагаж “Ард баян бол улс баян” гэсэн уриан дор өмчөө хөгжүүлэх бүр тодруулбал хотон дахь хонио есгөж өмчийн эрх чөлеөг олж авах чин хүслээр хөрөнгөлөг маягийн нийгмийг баримжаалж байхад гинжнээсээ өөр алдах зүйлгүй пролетариууд баячуудын хөрөнгийг хурааж, нийтийн өмч бий болгохыг зорьж хүн төрөлхтний үгээгүйчүүдийн олон зуун жилээр хүсэмжилж байсан социализмыг баримжаалж байв. Эцэг, эхийн хайр л хариу нэхдэггүй болохоос өөр бусад төрлийн ивгээл ямагт хариу нэхэж байдаг зүй жам ёсоор тусламжийн хариуг монголчууд, МАХН даанч өндөр үнээр төлөх ёстой байсныг тухайн үед тооцохын ч аргагүй байсан юм. “Дэлхий нийтийг гэхээсээ буурай Монголоо хөгжүүльье” өмчийг чөлөөтэй хөгжүүлж дэлхийн хамгийн хөгжингүй оронтой худалдаа наймаа эрхэлж, боловсрол дээд зэргээр эрхэмлэгдсэн тэр л тэргүүний оронд хойч халаагаа бэлдээ ингэснээр эдийн засгийн хувьд, улс төрийн хувьд ч тусгаар тогтнолоо бататгаж, Швейцар улс лугаа оршин тогтоо гэж Монголын өвөрмөц нөхцлийн тод томруун тусгасан монголын ирээдүйг товолсон ЭЗҮБ хөтөлбөр зэрэг монгол хүний сээтэл зүйн тусгаар тогтнолыг илэрхийлсэн олон олон дэвшилтэт үзэл санаа гадны хүчирхийлэлтэй тулгарч төрмөл шинж чанарын баримжааллаа алдаж учирмал баримжаалалд 1950-иад оны сүүлч болоход бүрэн чиглэгдэх болсон байна. МАН 1921 оны хөрөнгөлөг ардчилсан хувьсгалынхаа зорилтыг туштай хамгаалан зогсохдоо намынхаа шилдэг гишүүд, үе үеийн үндэсний дэвшилтэд сэхээрэлт хэсэг, монголын сор болсон эх орончдоо “ардын дайсан”, “баруунтан”, “зүүнтэн”, “япон тагнуулын хэрэг” зэрэг зүсэн бүрийн зохиомол хөргээр алдсан ч монголчуудын сээтэл зүйн тусгаар тогтнол бат бэх хэвээр үлдсэн байна.

Ийнхүү аливаа хувьсгалын хэв маягийг тухайн хувьсгалын шийдэж байгаа нийгмийн цөм болох асуудлууд, тухайлбал улс орноо, хүн арддаа чухам юуны төлөө хааш нь удирдаж байгаа болон, хувьсгалын үр дунд төлөвшин тогтнож буй нийгмийн байгууллын мөн чанараар тодорхойлон баримжаалагддаг бол 1921

оны үндэсний ардчилсан хувьсгал нь өрөөс жижиг өмчтөний буюу шууд дүгнэхэд жижиг хөрөнгөтний ардчилсан шинжийг агуулсан хөрөнгөлөг хувьсгал юм. 1921 оны хувьсгал гадны буюу их түрний үндэсний ашиг сонирхлоос эхтэй хүчирхийллийн тавилангаар 1950-иад оны сүүлч гэхэд өөрийн зорьсон гольдролоосоо гажсан нь хэн ч маргашгүй түүхэн үнэн юм.

Ишлэл

1. О.Латтимор. "Нүүдэлчид ба хувьсгалчид" УБ., 1994 он. 62-р тал.
2. Б.Явуухулан. Түүвэр зохиол. УБ., 1985 он. 387-р тал.
3. Ш.Бат-Очир. БНМАУ-ын шилжилтийн харьцааны үеийн зарим асуудал. УБ., 1957 он. 9-р тал.
4. Мөн тэнд.
5. Мөн тэнд.
6. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. УБ., 1979. 44-р тал.
7. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. I боть. УБ., 1966 он.
8. Мөн тэнд. 7-р тал. 37-38-р тал.
9. Мөн тэнд. 26-27-р тал.
10. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. УБ., 1979. 113-р тал.
11. А.Амар. Монголын товч түүх. Тэргүүн дэвтэр. УБ., 1934 он.
12. МАХН-ын III их хурал. УБ., 1966.
13. МАХН-ын түүхийн лекц. УБ., 1980. 172-р тал.
14. "Үнэн" сонин. 1995. №25.
15. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ., 1966. 100-р тал.
16. Мөн тэнд. 100-101-р тал.
17. ГХТА фонд 34-р шифр 5, хн. 05.